



БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

2016 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Агчуулга

1. Оршил	4
2. Судалгааны арга зүй	5
3. Судалгааны үр дүн	6
Нэг. Бизнесийн орчин	6
Хоёр. Бизнесийн ашиг орлого	9
Гурав. Хөрөнгө оруулалтын орчин	10
Дөрөв. Макро эдийн засгийн орчин	11
4. Бизнес итгэлийн индексийн трендүүд	16
5. Дүгнэлт	19

Оршил

МҮХАҮТ-аас жил болгон явуулдаг “Бизнес итгэлийн индекс” судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчид, олон нийтийн хүрээнд санал асуулгын болон онлайн хэлбэрээр 2016 оны 4-6 саруудад явууллаа.

Энэ судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, түүний өөрчлөлтийн талаарх хүлээлт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаар бизнес эрхлэгчид, иргэдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчинд таатай, таагүй нөлөө үзүүлж буй төрийн бодлого шийдвэр, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлууд зэрэг эдийн засаг бизнесийн орчны чухал үзүүлэлтүүдээр судалгаанд оролцогчдын саналыг тоймлон гаргахыг зорьсон болно.

Монголын Үндэсний Худалдаа
Аж Үйлдвэрийн Танхим


Судалгааны арга зүй

Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчид болон олон нийтийн дунд ганцаарчилсан ярилцлага авах болон онлайн хэлбэрээр 2016 оны 4-6 саруудад явуулж нийт 862 хүнийг хамруулсан.

Судалгааг хийхдээ санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын 526 хүн, 21 аймгаас аймаг болон сумын төвүүдийн 336 хүнийг хамруулсан болно.

Судалгааны түүврийн тархалтыг ангилсан дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлэв:

Хүснэгт 1



Судалгааны үр дүн


НЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИН

1.1. Бизнесийн орчны өөрчлөлт

Бизнесийн орчинг сайжруулахад дорвитой өрчлөлт оруулахад нөлөөлж чадаагүй ба “Муудсан” буюу “Огт өөрчлөгдөөгүй” гэсэн хариулт 73.1% санал авчээ.

Эдийн засгийн хямрал үргэлжилж, олон аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоосон, голлох экспортын бүтээгдэхүүн болох зэс, алт, нүүрсний үнэ унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэж чадахгүй байсаар байгаа боловч “Бизнесийн орчин эрс сайжирсан” гэсэн үнэлгээг судалгаанд оролцогчдийн 3.6% өгсөн нь өмнөх оны энэ үеэс 1.7 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1.1: 2016 оны эхний хагас жилд Монгол улсад бизнес, санхүүгийн орчин хэрхэн өөрчлөгдсөн гэж та үзэж байна вэ? (%)



Энэ онд “Маш их муудсан” (27.9%), “Өмнөхөөсөө бага зэрэг муудсан” (28.8%) гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогсдын 56.7% нь өгсөн ба энэ нь өмнөх оны энэ үеэс 6.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

1.2. Бизнесийн орчны өөрчлөлтийн хүлээлт

Бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн хүлээлт нь засгийн газар, бодлого боловсруулагчдын эдийн засаг, бизнесийн холбоотой бодлого шийдвэр гаргахад голлон анхаардаг хүчин зүйл юм.

Судалгаанд оролцогчдын 28.7% нь “Хариулж мэдэхгүй байна” буюу бусад асуултаас хамгийн их хариулт өгсөн нь 2016 оны эхний 6 сарын байдлаар Монгол улсын бизнес эрхлэгчид тодорхойгүй хүлээлттэй байна. Харин “маш их сайжирна”(2.1%), “бага зэрэг л сайжирна”(26%) гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогчдын 28.1% өгсөн ба энэ нь өмнөх оны энэ үеэс 1.2 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1.2: Улс орны бизнес санхүүгийн орчин 2016 оны хоёр дахь хагаст хэрхэн өөрчлөгдөнө гэж та төсөөлж байна вэ? (%)



1.3. Бизнесийн орчны үнэлгээ

Монгол улс Дэлхийн Банкны бизнес эрхлэлтийн индексээр 2015 онд дэлхийн 189 орноос 56-р байрт орж, өмнөх жилээс 3 байр ахисан байна. Бизнесийн итгэлийн индексийн үр дүнг нэгтгэвэл судалгаанд оролцогчдын 42% нь бизнесийн орчин “дунд”, 29.9% нь “муу”, 12.8% нь “маш муу” гэсэн үнэлгээ өглөө. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдагсан нийт хүний 85% нь Монголд бизнес эрхлэх орчин хангалтгүй буюу сайн бүрдэж чадаагүй гэсэн дүгнэлттэй байгаа нь өнгөрсөн оноос 3 нэгж хувиар муудсан үзүүлэлт юм.

Зураг 1.3: Бизнесийн орчны үнэлгээ (%)

1.4. Бизнесийн орчинг сайжруулах арга хэмжээ

Монгол улсын засгийн газраас бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр хамгийн түрүүнд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, бодлого шийдвэрийн тухай судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг дор үзүүллээ.


Зураг 1.4: Бизнесийн орчинг сайжруулахад юу саад болж байна вэ?

ХОЁР. БИЗНЕСИЙН АШИГ ОРЛОГО

2.1. Ашиг орлогын өөрчлөлт


Аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого нь тухайн улсад хууль эрх зүй, эдийн засаг, бизнесийн орчин нөхцөл хэрхэн бүрдсэнийг илтгэн харуулдаг чухал үзүүлэлт юм. Бизнес эрхлэх орчин нөхцөл сайжрахын хирээр аж ахуйн нэгжийн ашиг, орлого нэмэгддэг. Манай орны нөхцөлд өнгөрсөн хагас жилийн хугацаанд бизнесийн орлого нь ч, ашиг нь ч их хэмжээгээр өссөн гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын дөнгөж 1.2% эзэлсэн нь өмнөх оноос 0.3 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт судалгаанд оролцогсдын 36.5% нь “орлого ашиг хоёр буурсан” гэсэн хариулт өгч бизнес эрхлэгчдийн ашиг орлого өмнөх оноос 4.8 нэгж хувиар буурсан дүнтэй байна.

Зураг 2.1: 2016 оны эхний хагаст танай компанийн ашиг орлого өнгөрсөн оныхоос хэрхэн өөрчлөгдсөн бэ? (%)



2.2. Ашиг орлогын өөрчлөлтийн хүлээлт

Зураг 2.2: 2016 оны II хагаст танай компанийн ашиг орлогод ямар өөрчлөлт гарна гэж та үзэж байна вэ? (%)




2015 онд судалгаанд оролцогчдын 27.6% нь ашиг орлого нэмэгдэх байх гэсэн эерэг хүлээлттэй байсан бол энэ жилийн судалгаанд 23.2% болж буурчээ.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

3.1. Хөрөнгө оруулалтын өөрчлөлт

2015-2016 онуудад бизнес эрхлэгчдийн бизнестээ оруулсан хөрөнгө оруулалт 2014 онтой харьцуулахад 6-10 нэгж хувиар буурсан байна.

Зураг 3.1: Бизнестээ хөрөнгө оруулалт хийсэн эсэх (%)



Монголын эдийн засаг хүндрэлтэй байгаа, ойрын үед эдийн засаг сэргэх байдал харагдахгүй байгаа нь хөрөнгө оруулалтад нөлөөлсөн байна. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд бизнесийн үйл ажиллагаа хумигдах болсон, төрөөс бизнест хэт оролцох болсон, санхүү, хөрөнгө оруулалтын орчин муудсан, алдаатай хууль тогтоомж зэрэг шалтгаанууд нь бизнес, хөрөнгө оруулалтыг татраах үндсэн шалтгаан болсон гэж нэрлэсэн байна.

3.2. Хөрөнгө оруулалтын хүлээлт

Ирэх хагас жилийн хугацаанд Та бизнестээ ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх сонирхол, боломж байна уу гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 60% нь хөрөнгө оруулалт хийнэ гэсэн эерэг хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх онтой бараг адилхан (0.6 нэгж хувиар буурсан) үзүүлэлт болж байна.

Зураг 3.2: 2016 оны II хагаст танай компани бизнестээ их/бага ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх үү? (%)



ДӨРӨВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийн нэг нь макро эдийн засгийн орчин юм. Ядуурал, ажилгүйдэл зэргийг шийдэхэд бизнесийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой бөгөөд нэн ялангуяа нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ чиглэлд тодорхой үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн бизнесийн байгууллагын бараа бүтээгдэхүүний зардал, үнэ ханшид голлох нөлөө үзүүлдэг инфляцад бизнес эрхлэгчид ихээхэн анхаарал хандуулдаг. Иймд дээрх гурван хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогчдын саналыг авсан болно.

4.1. Инфляци

Иргэдийн амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаанд хамгийн хүчтэй нөлөөлдөг макро эдийн засгийн нэг гол хүчин зүйл бол инфляци юм. 2015 оны инфляцийн жилийн дундаж түвшин 9.8% байсан бөгөөд 2016 оны 6 сарын байдлаар инфляцийн түвшин 2.9% байна.

- **Инфляцийн өөрчлөлт**

2016 оны судалгаанд оролцогчдын 33% нь инфляцийн түвшин өссөн гэсэн хариулт өгсөн ба энэ нь өнгөрсөн онд 53% байсан дүнгээс буурсан үзүүлэлт юм. Харин ‘бага зэрэг буурсан’, ‘маш ихээр буурсан’ гэсэн хариулт 36,2%-д хүрсэн нь судалгаа явагдсан хугацааны хамгийн өндөр хувь ба судалгаа явагдсан хугацаан дахь инфляцийн түвшний талаар хамгийн эерэг үнэлгээг 2016 оны эхний 6 сард өгсөн байна.


Зураг 4.1.1: Инфляцийн түвшний үнэлгээ (%)



• Инфляцийн хүлээлт

Нийт судалгаанд оролцогчдын 30.4% хувь нь инфляци ирэх жилд ч өснө гэсэн хүлээлттэй байгаа нь судалгаа явагдсан хугацааны хамгийн бага дүнтэй инфляцийн түвшний хүлээлтийн талаарх хариулт юм. Харин инфляци өсөх буурахыг тааж хэлж чадахгүй нь гэсэн оролцогчд 35%-ийг эзэлж байгаа нь өмнөх оноос 5% нэгж хувиар нэмэгдсэн ба өөрөөр хэлбэл инфляцийг таамаглах, төсөөлөх боломж улам бүр муудаж байгааг энэ үзүүлэлт харуулж байна.

Зураг 4.1.2: Инфляцийн түвшний хүлээлт



4.2. Ажилгүйдэл

2016 онд Азийн сангаас явуулсан судалгаагаар 2016 оны 3 дугаар сарын байдлаар “ажилгүйдэл” нь 2015 онд 27.8 хувиас 2016 онд 28.4 хувь болж нэмэгдэн Монгол улсад хамгийн тулгамдсан асуудал хэвээр байна. Ажиллах хүчний судалгааны 2016 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд ажилгүй иргэд 143.5 мянга байсан. Харин хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайгч иргэд 2016 оны 5 дугаар сарын эцэст 47.3 мянга болсны 24.5 мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 59.0 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь, Дорнод, Увс, Дорноговь, Төв, Орхон, Булган аймагт улсын дунджаас 3.2-17.0 пунктээр илүү байна.

• Ажилгүйдлийн түвшний үнэлгээ

Хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэж, ялангуяа Улаанбаатар хотруу шилжин ирэх иргэдийн тоо жил ирэх тутам өсч байгаа нь ажилгүйдлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа хэдий ч гол нь төрийн зохистой, зөв бодлого шийдвэр, үйл ажиллагаа дутагдаж байгааг онцлон анхаарах шаардлагатай байгаа юм.

Зураг 4.2.1: Ажилгүйдлийн түвшний үнэлгээ



• Ажилгүйдлийн түвшний хүлээлт

2016 оны эхний хагаст нийт судалгаанд оролцогчид ирэх онд ажилгүйдэл өснө гэсэн хүлээлт нь өмнөх оноос 7 нэгж хувиар буурсан байна. Мөн “хэлж мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн хүний тоо өмнөх оноос 5 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 4.2.2: Ажилгүйдлийн түвшний хүлээлт




4.3. Ядуурал

• Ядуурлын өөрчлөлт

Судалгаанд оролцогчдын 39.2% нь өнгөрсөн жилийн хугацаанд ядуурал өссөн гэж үзэж байгаа нь өнгөрсөн оноос 3 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт судалгаанд оролцогчдын 8.8% нь өнгөрсөн жилийн хугацаанд ядуурал ямар нэг хэмжээгээр буурсан гэсэн бодолтой байгаа нь өнгөрсөн жилийн үзүүлэлттэй ойролцоо дүнтэй байна.

Зураг 4.3.1: Ядуурлын түвшний үнэлгээ



• Ядуурлын өөрчлөлтийн хүлээлт


Ядуурлын өөрчлөлтийн талаар судалгаанд оролцогчдын 49,5 хувь нь ядуурал ирэх жил өснө гэсэн хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх оноос 7.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 4.3.2: Ядуурлын түвшний хүлээлт




Бизнес итгэлийн индексийн трендүүд

БИЗНЕСИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ




2010 оноос хойш Бизнесийн орчны өөрчлөлтийн талаарх эерэг хариулт тогтмол буурах трендтэй байна.



Бизнесийн орчин сайжрах тухай хүлээлт сонгууль болох жилүүдэд эерэг дүн үзүүлдэг ба 'сонгуулийн нөлөөтэй' байна.

АШИГ ОРЛОГО

2012 оноос хойш бизнес эрхлэгчдийн ашиг, орлого өссөн тухай үзүүлэлт буурсан хандлагатай байна.



Жил ирэх тутам орлого ашиг буурч байгаа нь нэгдүгээрт, хямралын шинж тэмдэг, хоёрдугаарт, төрөөс бизнест оролцох оролцоо маш их болсон, хувийн компанид дарамт, шахалт үзүүлж, төр хувийн компанитай өрсөлдөх нь ихэссэн зэрэг үзүүлэлттэй холбоотой.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



2013 оны эхний 6 сарын байдлаар судалгаанд оролцогсдын 51% нь ямар нэгэн хэмжээгээр бизнестээ хөрөнгө оруулсан байсан бол 2016 онд 34% нь хөрөнгө оруулсан байна. 2012 оноос хойш бизнес эрхлэгчдийн бизнестээ оруулж буй хөрөнгө оруулалт буурсан байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Ажилгүйдэл, ядуурлын түвшин бууруулах гол хөшүүрэг нь бизнесийн идэвхижил бөгөөд нэн ялангуяа бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэн, дэмжсэнээр ажлын байр олныг бий болгож энэ хирээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нөхцөл бүрддэг. 2012 оноос хойш ерөнхийдөө ажилгүйдлын түвшин өсч, ядуурал ихссэн байна.

Инфляци



Ажилгүйдэл



Ядуурал



Дүгнэлт

2016 оны УИХ-ын сонгууль явагдаж Монгол улс шинэ УИХ, Засгийн газраа байгуулан улс орны өмнө тулгараад байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулахаар ажиллаж байна. Энэ шийдвэрлэх үед МҮХАҮТ-аас жил бүр явуулдаг “Бизнес итгэлийн индекс” судалгаагаар дамжуулан бизнесийн орчин дахь талуудын дуу хоолойг холбогдох байгууллагуудад хүргэж байна.

2012-2016 оны судалгааны дүнгээс үзэхэд иргэд, бизнес эрхлэгчид эдийн засаг, бизнесийн талаар авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, үр дүнд сэтгэл хангалуун биш байна.

2012 онд нийт судалгаанд оролцогсдын 13% нь бизнесийн орчинд ‘муу’ үнэлгээ өгч байсан бол энэ үзүүлэлт 2012 оноос хойш тасралтгүй нэмэгдэн 2016 онд судалгаанд оролцогсдын 43% нь өнөөгийн Монгол улсын бизнесийн орчинд ‘муу’ дүн тавьжээ. Бизнесийн орчинг сайжруулахад авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ нь дорвитой өөрчлөлт оруулахад нөлөөлж чадаагүй гэж 73.1% нь үзсэн байна. Төрийн нүсэр аппарат, тооцоо судалгаа багатай хариуцлагагүй төсвийн зарцуулалт, авилга хээл хахууль, зээлийн өндөр хүү, зээлийн хугацаа, хууль эрх зүйн тогтворгүй байдал зэрэг нь бизнес эрхлэхэд хамгийн их саад болж байгааг судалгаанд оролцогчид онцолсон байна.

Харин бизнес, санхүүгийн орчин сайжрах тухай хүлээлт 2010 оноос хойш ерөнхийдөө буурах хандлагатай мөн ‘сонгуулийн нөлөө’-тэй, өөрөөр хэлбэл орчин сайжрах тухай хүлээлт нь сонгуулийн жилүүдэд өсөлт ажиглагддаг зүй тогтолтой байдаг байна.

2012 оноос хойш бизнес эрхлэгчдийн ашиг орлого, бизнестээ оруулж буй хөрөнгө оруулалт буурсан трендтэй байна. Гэвч ирээдүйд хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлт нь 2016 онд өмнөх оноос сэргэсэн, эерэг дүнтэй гарчээ.

Макро эдийн засгийн чухал үзүүлэлтүүд болох ажилгүйдэл, ядуурлын түвшин ерөнхийдөө 2012 оноос хойш тасралтгүй өссөн ба ирэх жилд мөн өснө гэсэн хүлээлттэй байна. Харин инфляцийн түвшний талаарх хамгийн эерэг хариултыг энэ жилд өгсөн банийт судалгаанд оролцогчдын 36.2% нь ямар нэг хэмжээгээр инфляцийн түвшин буурсан гэж үзлээ. Гэвч инфляци ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх тухайд олонх хүмүүс тодорхойгүй хүлээлттэй байна.